



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 1/152

Жавхлант

Хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын (орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам) 3 дугаар зүйлийн 3.4.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн эзэмшлийн ариун цэврийн барилга, байгууламжийг нэмэгдүүлэх, засварлах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Отгонбаяр

Жавхлант багийн Засаг дарга

Нарийн бичгий дарга:

Э.Уугантуяа

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүн:

А.Алтанцэцэг

Үйлчлэгч

2.Захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн ажлыг хүлээн авч, ажлын тайлан, хүлээн авсан акт үйлдэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН